



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 141

танай _____ -ы № _____ -т

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ж.БАВУУДОРЖ ТАНАА**

Танай байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5-р сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү

Хавсралт...¹⁶ хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Ч.ЭРДЭНЭБААТАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Аудитын газрын Дарга,
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	13
4.2.1 Албан шаардлага	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
6. Албан шаардлага.....	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 140
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

025080235

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны кoл	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгдэ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	91,235,816.28	136,623,121.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		7,524,160.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		7,524,160.24
3121	Төгрөг		7,524,160.24
31211	Төрийн сангийн харилцах	-	6,779,572.18
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	744,588.06
33	АВЛАГА	811,817.76	66,070,354.15
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	40,854.15
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	66,029,500.00
335	Бусад авлага	811,817.76	-
3351	Байгууллагаас авах авлага	811,817.76	-
35	БАРАА МАТЕРИАЛ	90,423,998.52	63,028,607.54
351	Түүхий эд материал	81,920,603.82	52,094,511.84
35110	Тусгай зориулалттай материал	31,301,560.00	38,985,802.84
35130	Эм боох материал	50,619,043.82	13,108,709.00
354	Хангамжийн материал	5,733,394.70	8,654,095.70
35410	Бичиг хэргийн материал	681,850.00	669,350.00
35420	Аж ахуйн материал	2,883,400.00	2,788,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,642,000.00
35440	Түлц, шатах тослох материал	1,015,000.00	-
35450	Барилгын засварын материал	414,000.00	414,000.00
35460	Хүнсний материал	571,945.00	1,973,146.00
35470	Бусад хангамжийн материал	167,199.70	167,199.70
35600	Мал амьтад	2,770,000.00	2,280,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	592,871,516.92	605,112,088.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	592,871,516.92	605,112,088.32
392	Биет хөрөнгө	576,531,516.84	588,862,088.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	528,890,334.55	528,890,334.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,849,808.20)	(44,071,212.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,447,200.00	31,447,200.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,447,200.32)	(22,447,200.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,542,795.57	120,318,637.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,978,749.59)	(52,046,091.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,706,849.67	44,056,849.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,494,904.68)	(17,286,429.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,208,873.60	9,208,873.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,493,873.76)	(9,208,873.60)
393	Биет бус хөрөнгө	16,340,000.08	16,250,000.00
39301	Програм хангамж	867,000.00	867,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(746,999.92)	(837,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,220,000.00	16,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	684,107,333.20	741,735,210.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	24,605,952.44
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	24,605,952.44
413	Өглөг	-	24,605,952.44
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	24,605,952.44
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	684,107,333.20	717,129,257.81
51	Засгийн газрын хувь оролцоо	684,107,333.20	717,129,257.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	317,959,714.99	317,959,714.99
51101	Өмч: - төрийн	317,959,714.99	317,959,714.99
512	Хуримтлагдсан үр дүн	58,815,356.18	91,837,280.79
51210	Өмнөх үеийн үр дүн	58,815,356.18	58,815,356.18
51220	Тайланг үеийн үр дүн	-	33,021,924.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	307,332,262.03	307,332,262.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	684,107,333.20	741,735,210.25

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Давсны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	465,944,483.49	653,622,751.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	321,999,285.00	53,663,917.68
120	Нийтлэг татварын бус орлого	321,999,285.00	53,663,917.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	321,999,285.00	53,663,917.68
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	321,999,285.00	53,663,917.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,945,198.49	357,589,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээ санхүүжих	321,220,900.00	357,589,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,619,668.49	199,676,624.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	207,500.00	124,250,886.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	107,412,168.49	75,425,738.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,894,600.00	26,952,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,894,600.00	26,952,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,430,930.00	15,740,310.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,430,930.00	15,740,310.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	486,923,554.82	619,750,827.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,923,554.82	619,750,827.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	481,137,483.70	593,821,435.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,293,370.19	302,300,189.15
210101	Үндсэн цалин	222,877,798.19	203,752,810.54
210102	Нэмэгдэл	19,415,572.00	66,260,653.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,912,000.00
210104	Урамшуулал	-	28,374,725.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,146,403.89	40,115,852.52
210201	Тэтгэврийн даатгал	32,690,637.51	29,415,372.83
210202	Тэтгэмжийн даатгал	635,167.91	2,737,883.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	508,134.33	2,196,426.91
210204	Ажилгүйдлийн даатгал	119,314.92	520,506.07
210205	Эрүүл мэндийн даатгал	1,193,149.22	5,245,662.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,664,779.00	24,651,008.00
210301	Гэрэл, цахилгаан	2,929,779.00	3,632,346.00
210302	Түлш, халаалт	14,735,000.00	21,018,662.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,914,760.00	23,902,953.30
210401	Бичиг хэрэг	1,471,600.00	2,394,630.00
210402	Тээвэр, шатахуун	11,113,110.00	15,428,290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,439,100.00	2,432,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,000.00	1,211,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,817,450.00	2,393,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	912,500.00	43,333.30
2105	Нормативт зардал	109,204,340.46	154,355,845.96
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,727,855.46	143,710,936.96
210502	Хоол, хүнс	9,331,485.00	10,527,909.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	145,000.00	117,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	663,500.00	2,037,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	-
210604	Урсгал засвар	463,500.00	2,037,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,478,000.00	1,909,986.00
210702	Дотоод албан томилолт	1,478,000.00	1,909,986.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,949,048.00	791,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,299,448.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,250.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210807	Газрын төлбөр	238,900.00	227,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,823,282.16	43,756,050.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,196,843.00	3,870,780.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	28,626,439.16	39,885,270.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,786,071.12	25,929,392.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	350,000.00	25,620,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	25,620,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,436,071.12	309,392.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,436,071.12	309,392.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(20,979,071.33)	33,871,924.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,560,000.00	850,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,560,000.00	850,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,560,000.00)	(850,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(22,539,071.33)	33,021,924.61

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	317,959,714.99	307,332,262.03	58,815,356.18	-	684,107,333.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,959,714.99	307,332,262.03	58,815,356.18	-	684,107,333.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	33,021,924.61	-	33,021,924.61
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,959,714.99	307,332,262.03	91,837,280.79	-	717,129,257.81

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	438,885,918.60	517,808,668.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	438,885,918.60	517,808,668.76
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	321,220,900.00	357,589,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,220,900.00	357,589,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,339,488.60	117,526,458.76
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	207,500.00	58,221,386.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	81,131,988.60	59,305,072.76
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,894,600.00	26,952,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,894,600.00	26,952,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,430,930.00	15,740,310.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,430,930.00	15,740,310.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	440,509,511.60	510,284,508.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,509,511.60	510,284,508.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,911,622.72	484,355,116.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	254,182,069.14	302,286,078.15
210101	Үндсэн цалин	180,507,016.38	201,442,678.58
210102	Нэмэгдэл	54,038,123.76	68,557,629.27
210103	Уваа хоолны хөнгөлөлт	2,250,423.00	3,912,000.00
210104	Урамшуулал	17,386,506.00	28,373,770.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,130,109.42	40,157,661.67
210201	Тэтгэврийн даатгал	23,890,195.60	29,530,185.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,408,688.54	2,700,085.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,960,003.04	2,174,927.64
210204	Ажилгүйдлийн даатгал	461,003.62	523,181.70
210205	Эрүүл мэндийн даатгал	4,410,218.62	5,229,281.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,664,779.00	24,651,008.00
210301	Гэрэл, цахилгаан	2,929,779.00	3,632,346.00
210302	Түлш, халаалт	14,735,000.00	21,018,662.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,701,700.00	25,554,620.00
210401	Бичиг хэрэг	1,574,300.00	4,406,630.00
210402	Тээвэр, шатахуун	12,561,550.00	14,413,290.00
210403	Шуудан, холбоо, инженерийн төлбөр	1,439,100.00	2,432,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	346,000.00	865,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,780,750.00	3,437,700.00
2105	Нормативт зардал	82,138,849.60	79,362,882.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,976,639.60	63,804,772.70
210502	Хоол, хүнс	7,439,210.00	11,977,110.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,723,000.00	3,581,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,287,500.00	4,771,700.00
210601	Багаж, техник хэрэгсэл	200,000.00	-
210604	Урсгал засвар	1,087,500.00	4,771,700.00
2107	Томилголт, зочны зардал	1,478,000.00	1,909,986.00
210702	Дотоод албан томилголт	1,478,000.00	1,909,986.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,780,532.56	791,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,130,932.56	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,250.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	33,000.00
210807	Газрын төлбөр	238,900.00	227,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,548,083.00	4,869,330.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,548,083.00	4,869,330.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,597,888.88	25,929,392.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	350,000.00	25,620,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	25,620,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,643,924.76	309,392.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	832,107.00	309,392.00
213404	Хөрөнгийн	811,817.76	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,603,964.12	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,603,964.12	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(1,623,593.00)	7,524,160.24
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,623,593.00)	7,524,160.24
9	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,623,593.00	-
10	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,524,160.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,428,800.00	393,193,245.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,428,800.00	393,193,245.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,008,800.00	392,773,245.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,200,800.00	273,062,180.15
210101	Үндсэн цалин	165,649,000.00	172,644,790.58
210102	Нэмэгдэл	74,944,100.00	68,131,619.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,788,000.00	3,912,000.00
210104	Урамшуулал	24,847,400.00	28,373,770.30
210105	Гэрээт ажлын хөлс	5,972,300.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,287,100.00	36,362,907.67
210201	Тэтгэврийн даатгал	26,478,000.00	25,735,431.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,702,300.00	2,700,085.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,161,800.00	2,174,927.64
210204	Ажилгүйдлийн даатгал	540,500.00	523,181.70
210205	Эрүүл мэндийн даатгал	5,404,500.00	5,229,281.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,716,600.00	23,711,008.00
210301	Гэрэл, цахилгаан	3,299,000.00	3,572,346.00
210302	Түлш, халаалт	20,417,600.00	20,138,662.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,560,600.00	23,507,620.00
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	3,591,630.00
210402	Тээвэр, шатахуун	14,228,600.00	14,221,290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,432,000.00	2,432,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	865,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.00	2,397,700.00
2105	Нормативт зардал	25,901,300.00	25,876,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,301,300.00	13,295,650.00
210502	Хоол, хүнс	9,000,000.00	9,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,600,000.00	3,581,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,235,500.00	2,931,700.00
210604	Урсгал засвар	3,235,500.00	2,931,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,020,000.00	1,660,000.00
210702	Дотоод албан томилолт	2,020,000.00	1,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	982,000.00	791,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	250,000.00	227,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,104,900.00	4,869,330.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,104,900.00	4,869,330.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420,000.00	420,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	402,428,800.00	399,972,818.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	357,589,800.00	357,589,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	357,589,800.00	357,589,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,952,100.00	26,642,708.00
132001	Орон нутгийн төсвөөс	26,952,100.00	26,642,708.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,886,900.00	15,740,310.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,886,900.00	15,740,310.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,779,572.18

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,781,870.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,781,870.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,581,870.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,223,898.00
210101	Үндсэн цалин	28,797,888.00
210102	Нэмэгдэл	426,010.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,794,754.00
210201	Тэтгэврийн даатгал	3,794,754.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	940,000.00
210301	Гэрэл, цахилгаан	60,000.00
210302	Түлш, халаалт	880,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,047,000.00
210401	Бичиг хэрэг	815,000.00
210402	Тээвэр, шатахуун	192,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,040,000.00
2105	Нормативт зардал	53,486,232.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,509,122.70
210502	Хоол, хүнс	2,977,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,840,000.00
210604	Урсгал засвар	1,840,000.00
2107	Томилолт, зочны зардал	249,986.00
210702	Дотоод албан томилолт	249,986.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	117,526,458.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,526,458.76
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,221,386.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	59,305,072.76
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	744,588.06

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сумын ЭМТ нь эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 486.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Овоо сумын ЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 272.9 сая төгрөгөөр буюу 41.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	7,524.2	7,524.2
Авлага	811.8	66,070.4	65,258.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	90,424.0	63,028.6	(27,395.4)
Үндсэн хөрөнгө	592,871.5	605,112.1	12,240.6
Нийт хөрөнгө	684,107.3	741,735.2	57,627.9
Өр төлбөр	-	24,606.0	24,606.0
Засгийн газрын сан /Орон нутгийн сан	317,959.7	317,959.7	-
Өмнөх үеийн үр дүн	58,815.4	58,815.4	-
Тайлант оны үр дүн		33,021.9	33,021.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	307,332.3	307,332.3	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	684,107.3	741,735.2	57,627.9
Нийт орлого /Үр дүнгийн тайлан	465,944.5	653,622.8	187,678.3
Нийт зардал /Үр дүнгийн тайлан	486,923.6	619,750.8	132,827.3

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 7.5 сая төгрөг болж өссөн нь тайлант онд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 66.1 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 63.0 сая төгрөг болж 27.4 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь короновируст халдварын үед хэрэглэх эм, хамгаалах хэрэгслийн хэрэглээ өсч, нөөц багассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 605.1 сая төгрөг болж 12.2 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төлбөргүй шилжиж ирсэн 49.6 сая төгрөг, батлагдсан төсвөөс 2.5 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авсан зэрэг нийт 52.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 317.9 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 653.6 сая төгрөг болж, өмнөх оноос 187.7 сая төгрөгөөр буюу 40.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ковид-19 халдварт өвчний эмчилгээний зардлын санхүүжилт өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 619.7 сая төгрөг болж, өмнөх оноос 132.8 сая төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нормативт зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Энэ нь короновируст халдварын дэгдэлттэй холоотой илүү цагийн хөлс, урамшуулал, эм эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, эмч ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд орон нутгийн төсвөөс 26.9 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 17.9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 357.6 сая төгрөг, нийт 402.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээс 357.6 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 15.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 26.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 393.2 сая төгрөгийг зарцуулж, харилцах дансанд 6.8 сая төгрөгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна. Төсвийн гүйцэтгэл 97.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМДС-аас короновируст халдвараар гэрийн хяналт болон тусгаарлах байрны хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилт 18.4 сая төгрөг, дархлаажуулалтын вакцины санхүүжилт 14.0 сая төгрөг, эрүүл мэндийн ажиллагсад олгох нэг удаагийн тэтгэмжийн санхүүжилт 25.2 сая төгрөг, эргэлтийн эмийн сангийн хөнгөлөлттэй эмийн санхүүжилт 8.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 51.7 сая төгрөг, нийт 117.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

Бичиг хэргийн зардлаас 1.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хэсэгт орлогын 468.6 сая төгрөгийн 20 гүйлгээ, зарлагын 37.4 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалтын 84.8 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийг зохих хэсэгт үнэн зөв мэдээлээгүй зэрэг нийт 590.8 өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн боловч зөрчил дахин давтагдсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 албан шаардлага 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 75 хувь байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал бүртгэгдээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 591.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 2 албан шаардлага хүргүүлэв.

4.2.1 Албан шаардлага

- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хэсэгт орлогын 468.6 сая төгрөгийн 20 гүйлгээ , зарлагын 37.4 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалтын 84.8 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийг зохих хэсэгт үнэн зөв мэдээлээгүй зэрэг нийт 590.8 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Бичиг хэргийн зардлаас 1.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв	1	1.0					1	1.0		
Дүн		1	1.0					1	1.0		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв	1	590.8					1	590.8		
Дүн		1	590.8					1	590.8		
Нийт дүн		2	591.8					2	591.8		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 80/А2370449
ХТН - 2022/133/НА - СТА - ТНЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хэсэгт орлогын 468.6 сая төгрөгийн 20 гүйлгээ, зарлагын 37.4 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалтын 84.8 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийг зохих хэсэгт үнэн зөв мэдээлдэггүй зэрэг нийт 590.8 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ж.Бавуудорж, нягтлан бодогч Н.Алтансүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 79/А2370449
ХЭА-2022/133/НА-СТА ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бичиг хэргийн зардлаас 1.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар" гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ж.Бавуудорж, нягтлан бодогч Н.Алтансүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА

